| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,067,498.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,067,498.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **81,340,272.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,874,472.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,465,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **124,525,048.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **115,186,187.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 68,181,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 47,005,087.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **9,338,861.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 0 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 9,338,861.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **348,099,813.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **348,099,813.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 310,586,613.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 37,513,200.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **12,526,738.00** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 12,526,738.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын орлогын болон мэдээ тайлан гаргалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 01/42 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, зөв бодлого, оновчтой шийдэл, тогтвортой хөгжлийг ханган иргэд үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамж, стандартын шаардлагад нийцсэн нийгэм эдийн засгийн эрчимтэй өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Батсүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Сумын санхүүгийн албанаас мөнгөн хөрөнгө, бараа материал, төсвийн зардалд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар ажил төлөвлөсөн ч хэрэгжилтийг тайлагнаж ажиллаагүй байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид эрсдэлд суурилан дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батсүмбэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 6,318,454.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 94,777.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 71,083.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 5,200,277.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 78,005.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 16,772.0 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувиар буюу 56,254.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 12 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

***Орлогын талаар:***

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн орлого 516,512.3 мянган төгрөг, аймгийн санхүүгийн дэмжлэг 476,954.1 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 89,349.1 мянган төгрөг, тусгай

зориулалтын шилжүүлэг 2,929,221.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 37,235.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 346,099.8 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 142,873.9 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн борлуулалтын орлого 164,342.3 мянган төгрөг нийт 4,702,588.4 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн, зарцуулсан байна.

Батсүмбэр сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 417,280.3 мянган төгрөг, татварын бус орлогыг 113,000.0 мянган төгрөг, нийт 530,280.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 418,725.6 мянган төгрөг, татварын бус орлого 97,786.7 мянган төгрөг, нийт 516,512.3 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 11,767.0 мянган төгрөг буюу 2,2 хувиар тасарсан байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр хэрхэн биелүүлснийг шалгахад ойн төлбөр 115,857.5 мянган төгрөгөөр буюу 42.5 хувиар, нэр заах ангилагдаагүй орлого 30,156.2 мянган төгрөг буюу 31,7 хувиар, буу 1,228.0 мянган төгрөг буюу 45,3 хувиар нийт 3 нэр төрөлд187,241.7 мянган төгрөгөөр тасарсан байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 78,867.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 50,274.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 129,141.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 165,656.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 594,582.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 555,433.3 мянган төгрөг, шилжүүлэн авсан 19,936.7 мянган төгрөг, бусад 696.7 мянган төгрөг, нийт 1,170,649.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 1,068,140.9 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

***Авлага, өглөгийн талаар*:**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 215,689.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 323,959.5 мянган төгрөг, ажиллагчидтай холбоотой авлага 623.0 мянган төгрөг нийт 540,271.5 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 312,936.9 мянган төгрөг буюу 57,9 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 159,195.9 мянган төгрөг буюу 29,5 хувийг ЭМТ, 52,068.0 мянган төгрөг буюу 9,6 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн авлага эзэлж байна.

Байгууллагад төлөх 583.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 1,442.0 мянган төгрөг, нийт 2,028.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Нийт өрийн 1,992.0 мянган төгрөг буюу 98,2 хувийг ЭМТ-ийн өр эзэлж байна.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 504,601.4 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 26,621.3 мянган төгрөг, нийт 531,222.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 547399.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 7,815,586.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/ төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 491,501,841.8 | 531,222,650.7 | 39,720,809.0 |
| Авлага | 419,902,296.2 | 540,271,500.3 | 120,369,204.1 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 453,891,087.7 | 556,399,638.90 | 102,508,551.2 |
| Нөөцийн бараа /сурах бичиг/ | | - | - |
| Үндсэн хөрөнгө | 8,063,245,714.8 | 7,815,586,431.8 | (247,659,283.0) |
| **Нийт хөрөнгө** | **9,428,540,940.4** | **9,443,480,221.8** | **14,939,281.3** |
| Өр төлбөр | 2,299,358.2 | 2,028,282.5 | (271,075.7) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 9,426,241,582.3 | 9,441,451,939.3 | 15,210,357.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **9,428,540,940.4** | **9,443,480,221.8** | **14,939,281.3** |

Бараа материалын дансны үлдэгдэл 556,399.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 102,508.6 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бусад хангамжийн материал, нөөц, бараа материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,815,586.4 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 247,659.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд ЗДТГ ЕБС, Цэцэрлэг үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна. Тайлант онд үндсэн хөрөнгө дансанд шилжих үлдэгдлээс ЗДТГ-т 19,849.0 мянган төгрөг, ЭМТ-д 12,229,0 мянган төгрөг, хандиваар Соёлын төвд 19,980.0 мянган төгрөг, Эмнэлэгт 16,393.9 мянган төгрөг хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,441,451.9 мянган төгрөг болж 15,210.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 4,866,016.4 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Батсүмбэр сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 4 дүгээр тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 530,280.3 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 4,636,909.6 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 4,536,589.6 мянган төгрөгөөр тодотгон баталсан ба сум хөгжүүлэх сангийн орлогыг 100,320.0 мянган төгрөгөөр, нийт 4,636,909.6 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 229,106.8 мянган төгрөгөөр бууруулан санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 7 хөтөлбөр 20 арга хэмжээнд зориулан нийт 4,503,709.6 мянган төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг нийт 4,597,863.3 мянган төгрөгөөр тайлагнасан нь ИТХ-ын батлагдсан

төлөвлөгөөнөөс ЕБС 86,039.5 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлого 2,000.0 мянган төгрөгөөр дутуу, шилжих үлдэгдэл 182,194.2 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй байна.

Нийт зардлын 3,394,064.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 986,252.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 156,273.1 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 100,320.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 3,889,305.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 71,621.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 85,230.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 4,046,156.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 132,002.7 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 63,935.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,046,156.4 мянган төгрөг буюу 87,96 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 348,099.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 211,048.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 115,186.2 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 9,338.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 12,526.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Батсүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторууд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС –ийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-т 6,37.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 123,852.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага, ИТХ-д 3,491.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, СХС-д 46,077.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 14,257.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж, ОНХС-д 63,302.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 84,011.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Соёлын төвд 1,129.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага тус тус өгөгдсөн байна.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Уваа-Уул аудит ХХК аудит хийж, ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, эргэлтийн эмийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЕБС-д 586.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 17,475.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж, Цэцэрлэгт 5,566.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Эрүүл мэндийн төвд 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

## 3.8 Аудитын гол асуудал

Батсүмбэр сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор тодотгон баталсан 3,907,520.8 мянган төгрөгийн төсвийг Төсвийн

гүйцэтгэлийн тайланд 94,153.7 мянган төгрөгөөр буюу ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс тусгай зориулалтын шилжүүлэг 86,039.5 мянган төгрөг, ЗДТГ-ын 2,001.0 мянган төгрөгөөр, шилжих үлдэгдэл 182,194.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа зөрчлийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулах шаардлагатай байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад сумын ИТХ 233.0 мянган төгрөг, ЕБС 4,747.2 мянган төгрөг дутуу, Соёлын төв 178.6 мянган төгрөг, Ойн анги 1,265.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн төв 859.6 мянган төгрөг, Цэцэрлэг 8,806.7 мянган төгрөг, ЗДТГ 105,832.8 мянган төгрөгөөр тус тус илүү зөрүүтэй байна. Орон нутгийн татварын орлогыг тооцооллыг тухай бүрд хийдэггүйгээс аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтоор илүү, дутуу үлдэгдэлтэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээлэлд нягтлан бодогчийн мэдээллийг солиогүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл болон ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил гаргасан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 6 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 05/307 дугаар албан бичгээр ирүүлсэн ба СХС, ОНХС-ийн зөвлөмж бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг зөрүүтэй

мэдээлж буй зөрчлийг таслан зогсоосон эсэх болон ковидын зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 437,771.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 22,927.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,382.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 305,189.5 мянган төгрөгийн албан шаардлага, 131,199.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй орлогыг үндсэн хөрөнгө, бараа материалын тодруулга тайлантай тулгахад үндсэн хөрөнгө 3,550.0 мянган төгрөгөөр, бараа материал 6,670.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, цалин, шимтгэлийн зардлыг үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээтэй тулгахад үндсэн цалин, нэмэгдлийг 12,707.3 мянган төгрөгөөр нийт 22,927.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Газар эзэмших, ашиглах эрх шилжилтийн бүртгэлийн судалгаагаар 40 иргэний 28,396.0 мянган төгрөгийн үнэ бүхий газрын эрхийг шилжүүлсэнтэй холбоотой 2,840.2 мянган төгрөгийн татвар ногдуулснаас 652.6 мянган төгрөгийг хуулийн дагуу чөлөөлж, 805.4 мянган төгрөгийг төлж 1,382.3 мянган төгрөг төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

### 4.3 Албан шаардлага

Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн орлого батлагдсан төлөвлөгөөнөөс ойн төлбөр 115,857.5 мянган төгрөгөөр буюу 42.5 хувиар, нэр зааж ангилагдаагүй орлого 30,156.2 мянган төгрөг буюу 31,7 хувиар, галт зэвсэгийн албан татвар 1,228.0 мянган төгрөг буюу 45,3 хувиар нийт 3 нэр төрөлд 187,241.7 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон

нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Төсөвт байгууллагуудын татварын өр, авлагын тодорхойлолтыг татварын цахим системээр гаргахад төсвийн нийт 7 байгууллагад 11,104.0 мянган төгрөг дутуу, 123,067.4 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй гэж тайлагнасан нь ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн татварын өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д ”аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Орон нутгийн орлогын мэдээ нь аймгийн Татварын хэлтэс болон улсын байцаагчийн мэдээгээр 512,026.5 мянган төгрөг, нэгтгэсэн тайлангаар 516,512.3 мянган төгрөг нийт 5,984.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой***

*1.1. Илрүүлэлт:*

Сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх татварын орлого 417,279.3 мянган төгрөг, татварын бус орлого 113,001.0 мянган төгрөг, нийт 530,280.3 мянган төгрөгөөр баталсан байна. Тодотгосон төлөвлөгөөнөөс нэгтгэсэн тайлангийн орлогын гүйцэтгэлийн тайланд ТГӨО 2,000.0 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайланд ТЗШ-ийн байгууллагын санхүүжилт 86,039.5 мянган төгрөг дутуу, төсвийн шилжих үлдэгдлийг 182,194.2 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Сумын жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэхдээ сумын ИТХ-аас баталж ирүүлсэн тогтоолын тоо, дүн зөрүүтэй алдааг засуулж авах бөгөөд тогтоол нь төлөвлөгөөнөөс зөрүүтэй байсан зөрчлийг давтан гаргахгүй байх

*1.2. Илрүүлэлт:*

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарлагын нийт хэмжээг 4,257,759.7 мянган төгрөгөөр баталсан байна. ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 4,536,589.6 мянган төгрөг, СХС 100,320.0 мянган төгрөгөөр, нийт зардал 4,636,909.6 мянган төгрөгөөр тодотгон батлагдсаныг төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлантай тулгахад 37,046.2 мянган төгрөгөөр төлөвлөгөөг зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь тогтоолоос ЗДТГ 34,194.2 мянган төгрөгөөр, ЭМТ 71,484.0 мянган төгрөгөөр илүү, СӨБ 116,864.0 мянган төгрөгөөр, ЕБС 25,860.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Сумын жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэхдээ сумын ИТХ-аас баталж ирүүлсэн тогтоолын тоо, дүн зөрүүтэй алдааг засуулж авах бөгөөд тогтоол нь төлөвлөгөөнөөс зөрүүтэй байсан зөрчлийг давтан гаргахгүй байх

### 2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

*2.1. Илрүүлэлт:*

Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолын дагуу "ЗДТГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ыг сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн захирамжаар баталж, дотоод хяналтын багийн 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, жилийн ажлын төлөвлөгөө гарган ажилласан гэх боловч төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд болон орлого төвлөрүүлэх бусад эрсдэлтэй асуудалд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д "дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад

чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг гэж ойлгоно", Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-д "Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлж ажиллах

*2.2. Илрүүлэлт:*

Шилэн дансны мэдээлэлд нягтлан бодогчийн мэдээллийг солиогүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл болон ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил гаргасан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй болон алдаатай мэдээллийг засаж, төсвийн төсөл болон төсвийн гүйцэтгэлийн хэмнэлтийн тайлбар шалтгааныг ойлгомжтой мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Аудитын дүгнэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Батсүмбэр сумын Засаг дарга | 8 | 460,699.3 | 1 | 22,927.6 | 1 | 1,382.3 | 3 | 305,189.5 | 4 | 131,199.9 | Зөрчилгүй |
| | **ТТЗ-ийн дүн** | **8** | **460,699.3** | **1** | **22,927.6** | **1** | **1,382.3** | **3** | **305,189.5** | **4** | **131,199.9** | |
| 2 | Батсүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | 3,491.3 | - | - | - | - | 1 | 3,491.3 | - | - | |
| 3 | Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар | 5 | 131,495.4 | 1 | 1,245.2 | 2 | 6,397.9 | 3 | 123,852.2 | - | - | Хязгаарлалттай |
| 4 | Батсүмбэр сум дундын Ойн анги | 4 | 48,195.5 | - | - | 1 | 38.0 | 1 | 44,349.3 | 2 | 3,808.3 | Зөрчилгүй |
| 5 | Батсүмбэр сумын Соёлын төв | 1 | 1,129.6 | - | - | - | - | 1 | 1,129.6 | - | - | |
| 6 | Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль | 4 | 18,062.4 | - | - | 1 | 586.5 | 1 | 17,475.9 | 2 | - | Зөрчилгүй |
| 7 | Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэг | 2 | 5,566.2 | - | - | - | - | - | - | 2 | 5,566.2 | Зөрчилгүй |
| 8 | Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төв | 3 | 710,200.6 | 2 | 710,200.6 | - | - | 1 | - | 2 | - | Зөрчилгүй |
| | **ТШЗ-ийн дүн** | **20** | **918,141.0** | **3** | **711,445.8** | **4** | **7,022.4** | **8** | **190,298.3** | **8** | **9,374.5** | |
| 9 | Батсүмбэр сумын Сум хөгжүүлэх сан | 2 | 60,335.1 | - | - | - | - | 1 | 46,077.4 | 1 | 14,257.7 | |
| 10 | Батсүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан | 4 | 147,313.8 | - | - | - | - | 1 | 63,302.1 | 3 | 84,011.8 | |
| 11 | Батсүмбэр сумын Эмийн эргэлтийн сан | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| | **ОНТС-ийн дүн** | **6** | **207,648.9** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **109,379.5** | **4** | **98,269.4** | |
| | **Нийт дүн** | **34** | **1,586,489.2** | **4** | **734,373.4** | **5** | **8,404.7** | **13** | **604,867.3** | **16** | **238,843.8** | |